

бүртгэл, мэдээллийн сан гэсэн ангилал зэрэглэлтэй байж сургалтанд хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн алба хаагч сонгон шалгаруулалтын онооны дараалалаар эрэмбэлэгдсэн байх зарчимд тулгуурласан байх ёстой.

Эцэст нь дүгнэхэд төрийн тусгай чиглэлтэй байгууллагын удирдах албан тушаалтанг нэгдсэн бодлогоор сургаж бэлтгэх нь төрийн алба мэргэшсэн чадварлаг байх суурь зарчмыг хангах, төрийн албаны төлөвшил, цаашлаад чадварлаг мэргэжлийн удирдах албан тушаалтныг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

*Хууль сахиулахын их сургуулийн
Сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн,
цагдаагийн дэд хурандаа А.Амарсайхан
Мэргэжилтэн И. Ургамал*

УДИРДАХ АЛБА ХААГЧДЫГ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН АРГА ЗӨЙН ШИНЭТГЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Хураангуй. Төрийн тусгай чиглэлтэй байгууллагуудын удирдах албан тушаалтныг бэлтгэж ирсэн одоогийн уламжлалт сургалтын хөтөлбөр, агуулгад шинэчлэл хийх замаар дэлхийн нөхцөл байдалд орнуудад удирдах албан хаагчдыг бэлтгэж байгаа жишигт хөрөнгө, ул.маар удирдах албан хаагчдын мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлж байх хэрэгцээ шаардлага бий болж байна.

Төлхөөр г. Удирдах албан тушаалтан, сургалт, давтан сургалт, мэргэшүүлэх сургалт, удирдах албан хаагчийн сургалт.

Сүүлийн жилүүдэд тогтвортой хөгжлийн асуудал зөвхөн нэг улсаар хязгаарлагдахгүй болж бүс нутгийн, цаашлаад дэлхий нийтийн анхаарлын төвд байх тулгамдсан асуудал болохыг хэлээн зөвшөөрөлд байна. Ялангуяа эдийн засаг, нийгэм, соёлын зэрэг бүхий л салбарын даяаршил улам бүр эрчимжиж байгаа энэ зууны хувьд хэрхэн хамтаар хөгжих, даяаршил болон дангааршил, нийтлэгжих болон ондооших, харилцан эсрэг хандлагыг хэлээн зөвшөөрөх, зэрэгцэн орших боломжийг тодорхойлох шинэ зууны иргэдийг бэлтгэх нь боловсролын салбарын гол зорилт болоод байна.

Ертөнцийг харах шинэ үзэл хандлага, сэтгэлгээний шинэ арга барил, үйл ажиллагааны шинэ хэв маяг улс орны тогтвортой хөгжлийн загварыг тодорхойлж байна. Энэтэй холбоотойгоор Нэгдсэн Ндэстний

Байгууллагын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны байгууллага /ЮНЕСКО/-ын "Дунд хугацааны хөгжлийн стратеги" (2014-2020) бодлогын баримт бичигт боловсролын шинэчлэлийн асуудлыг онцгойлон чухалчлан авч үзжээ¹.

Боловсролын салбарт бодлогын шинэчлэл хийх, бөх шатны боловсролын чанарыг сайжруулах талаар олон улсын түвшинд анхаарал хандуулж байгаа. нийгмийн хөлээлт улам бүр хөгжтэй мэдрэгдэж эхэлсэн энэ цаг үед Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдлагын чадавхи, бүтээмжийг дээшлүүлэх арга замыг тодорхойлох үндсэн нөхцөл нь боловсролын инновацийн цогц бодлого. сургалтын технологи, арга зүйн шинэчлэл юм. Ялангуяа дэлхийн томоохон их. дээд сургуулиудын хөгжлийн стратегид бодит үрчлөлтөд гарч, сургалтын уламжлалт технологи. арга зүйг шинэчлэн явцуу хэрэнд ажиллах чадвартай мэргэжилтэн бэлтгэхээс аль болох татгалзаж харин насан туршдаа суралцах. мэдлэгийг үргэлжлэн бүтээх. аливаа асуудалд ялгамжтай хандах чадвартай. бүтээлч, идэвхитэй. хариуцлагатай дэлхийн иргэнийг бэлтгэхэд анхаарч байгаа энэ цаг үед Монгол Улсын үндэсний боловсролын салбарын хөгжлийг ангид авч үзэх боломжтой.

Манай улсын хувьд хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах түрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдах алба хаагчдыг мэргэшүүлэн бэлтгэх үндэсний тогтолцоо бүрэн төлөвшсөнгүй, Хууль сахиулахын их сургуулийг түшиглэн удирдлагын стратеги, тактикийн түвшний боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг 2012 оноос хэрэгжүүлж эхэлсэн зэрэг нөхцөл байдал нь энэ түвшний сургалтын технологи, сургах арга зүйг орчин цагийн хэрэгцээнд тулгуурлан шинээр боловсруулах, уламжлалт технологийг оновчтой хослуулах, гадны шилдэг туршлагыг үүрийн онцлогт тохируулан нутагшуулах чиглэлээр анхааран судлах шаардлагатайг илэрхийлж байна.

Уламжлалт сургалтын арга зүй болох багш түвтэй, судлагдахууны сэдэвт суурилсан, мэдлэг олгоход чиглэсэн, танхимын сургалтад түшиглэсэн арга зүйгээс суралцагч түвтэй, мэдлэгийг бүтээх, түлшнийг хэрэглээ болгох чадвар эзэмшүүлэх, чадамжид суурилсан арга зүйд шилжих явдал нь Монгол Улсын дээд боловсролын шинэчлэлийн үндсэн чиглэлийн нэг юм. Түүрхс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)-ын 3 дугаар зүйлийн 3.6. дахь хэсэгт "Дээд болон

¹ Цахим холбоос: <http://unesdoc.unesco.org/imapfiles/0022/0Q2278/227860e.pdf>

мэргэжлийн боловсрол нь хөгжлийн даяарчлагдсан зах зээлд амжилттай өрсөлдөх, бие даан ажлын байр бий болгох, улс ндэстний болон орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг ндэсний онцлогт тулгуурлан шийдвэрлэх. ндэсний инновацийн чадавхийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах чадамж эзэмших өө хэмээн хөгжүүлнэ¹" гэж дээд боловсролын сургалтын байгууллагын хөгжлийн стратегийг тодорхойлоод байна.

Улс ндэстний болон орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг ндэсний онцлогт тулгуурлан шийдвэрлэх чадвартай байх нь удирдах албан тушаалтны хувьд эзэмшсэн байвал зохих чадвар бөгөөд Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын удирдлагын академийн хэрэгжүүлж буй "Хууль сахиулахын удирдлага", "Стратеги-тактик. удирдлага" магистрын сургалтын хөтөлбөрийн зорилт мөн нэнтэй хамааралтай юм.

ХХ зууны дунд өөс эхлэн сургалтын уламжлалт технологийг шинэчлэх. шинэ арга зүйг сургалтын процесст нэвтрүүлэх талаар боловсрол судлалын мэргэжилтнүүд анхаарлаа хандуулах болсон бөгөөд профессор Ховард Барроугийн² анхлан боловсруулсан "Асуудалд суурилсан сургалтын арга зүй" (Problem Based Learning)-г анагаах ухааны болон инженерийн дээд боловсролын сургалтад нэвтрүүлж эхэлсэн нь өр дөнтэй хэрэгжиж байна. 1990-ээд оноос Канад Улс хууль сахиулах болон цагдаагийн боловсон хүчнийг бэлтгэх сургалтад энэ арга зүйг нэвтрүүлж эхэлсэн байна³.

Асуудалд суурилсан сургалт бол сурагч төвтэй сургалтын арга зүй бөгөөд суралцагчдад судалгаа явуулах, онол практикаа нэгтгэх, олж авсан мэдлэг, ур чадвараа тухайн тодорхойлох асуудлын өр

¹ Монгол Улсын Их Хурлын 2015 оны I дүгээр сарын 29-ны өдөр 12 дугаар тогтоолоор баталсан. Цахим эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/10935> холбоос:

² Barrows HS, Tamblyn, R. Problem-Based Learning: An Approach to Medical Education. New York: Springer, 1980.

³ Vander Kooi, G. (2006). Problem-based learning: An attitudinal study of police academy students (Doctoral dissertation, Western Michigan University, 2006). Eric Paul Werth. (2009). Problem-based learning in police academies: adult learning principles utilized by police trainers. (Doctoral dissertation, Liberty University, 2009)

ашигтай шийдлийг гаргахад ашиглах боломж^{1 2}, уян хатан ойлголт, насан туршдаа суралцах ур чадварыг олгодог.²

Суралцагчид багшаар удирдуулах биш $\square\square\square$ бие даан суралцаж, тодорхой асуудлыг шийдэхдээ олж авсан шинэ мэдлэгээ ашиглаж, $\square\square$ ний $\square$ р ашгийг тунгаан бодно. Багш нь асуудалд суурилсан сургалтын явцад мэдлэг дамжуулах гэхээсээ ил $\square\square$ сургалтын $\square$ йл явцыг идэвхиж $\square\square$ лэгч байна.

Сургалтын уламжлалт технологид тулгуурласан судлагдахуунд суурилсан сургалт нь суралцагч юу мэдэх ёстойг багш лекцийн хичээлээр чигл $\square\square$ лж, тухайн мэдлэгийг ойлгож, тогтоосноор бодит байдалд $\square\square$ ссэн асуудлыг шийдвэрлэх багш $\square\square$ втэй сургалтын арга з $\square$ й байдаг бол асуудалд суурилсан сургалт нь судлах сэдвийн х $\square$ рээнд байгаа асуудлыг эрэлхийлж томъёолох, тухайн асуудалтай холбоотой мэдэх шаардлагатай мэдлэгийн х $\square$ рээг тогтоон судлах. мэдлэгээ ашиглан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох суралцагч $\square\square$ втэй идэвхитэй сургалтын арга з $\square$ й юм.

Сургалтын гол ц $\square$ м болох асуудал (PCE)-ыг бодит практикт тулгарч буй “Problem” буюу бэрхшээл. “Challenge” буюу мэргэжлийн $\square$ йл ажиллагааг боловсронгуй болгох, сайжруулах боломж, “Emerging issue” буюу ирээд $\square$ йд $\square\square$ сч болох асуудлыг урьдчилан томъёолох гэж тодорхойлж болно. Иймээс асуудлыг шийдэх нь дасгал хийхээс $\square\square$ р з $\square$ йл юм. “Дасгал ажил” хийхэд $\square$ нг $\square$ рс $\square$ н явцыг эргэн санаж хэрэглэдэг бол “асуудлыг шийдэх”-дээ тухайн асуудалд хэрхэн хандах, яаж эхлэхээ мэдэх $\square$ й байдаг учраас энэ нь эргээд шинэ мэдлэгийг шаарддаг $\square\square$ дийг $\square$ й судалгаа хийх, асуудлыг шийдэх нь нэг зоосны хоёр тал гэж $\square$ зжээ. Гэхдээ энэ нь багшийн $\square\square$ рэг хариуцлагыг бууруулсан ойлголт биш б $\square$ г $\square$ д багш хичээлийг удирдан явуулахаас ил $\square\square$ тэйгээр чигл $\square\square$ лэгч, зохицуулагчийн $\square\square$ рэг давамгайлах ёстой гэдгээр тайлбарлаж болно. Энэх $\square\square$ сургалтын арга з $\square$ й нь суралцагчдад уян хатан мэдлэг, системтэйгээр сэтгэх арга, асуудлыг $\square$ р д $\square$ нтэйгээр шийдвэрлэх ур чадвар, бие даан насан туршдаа суралцах чадвар, $\square$ р ашигтай хамтран ажиллах ур чадвар, шинийг санаачлах чадвар олгоход давуу байдал олгодгоороо $\square\square$ рийн албаны чадахуйн зарчим, дээд

¹ Savery. John R (2006) “Over view of problem based learning: Definitions and Distinctions,” Interdisciplinary Journal of problem-based learning; Vol. 1: ISs. 1, Article 3. P-12

² Hmelo-Silver, Cindy E (2004) “Problem based Learning: What and How Do Students Learn?” Educational Psychology Review, Vol. 16, p.235

боловсролын шинэчлэлийн зорилтыг шийдвэрлэх чухал ач холбогдолтой юм.

Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын удирдлагын академийн хэрэгжүүлж буй "Стратеги-тактик, удирдлага" мэргэжлийн магистрын сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа сургалтын агуулгын 40 хэртэл хувийг танхимын сургалтаар, 60-аас доошгүй хувийг судалгаа, туршилт, дадлагын сургалтаар олгохоор төлөвлөж, дээд боловсролын болон мэргэжлийн суурь хичээлд дийг академик буюу судлагдахуунд суурилсан арга зөйд тулгуурлах, мэргэжлийн хичээлд дийг судалгаа болон асуудалд суурилсан сургалтын арга зөйд тулгуурлах зарчим баримталж, асуудалд суурилсан сургалтын зарим аргыг сургалтын өйл явцад туршиж эхлээд байна.

Энэ нь сургалтын хөтөлбөрийн тогтвортой хөгжлийг хангах, сургалтын орчныг өөрчлөх, багшийн заах арга барилыг өөрчлөх, хичээлийн уламжлалт хэлбэрүүдийг идэвхитэй сургалтын бусад хэлбэрүүдээр баяжуулах, сургалтын хэрэглэгдэхгүйн сурах бичиг, гарын авлагыг олшруулах, мэргэжлийн өйл ажиллагаатай холбоотой мэдээллийн сангуудыг өр дөнтэйгээр ашиглах боломжийг бүрдүүлэх, мэдээллийн технологийн ололтыг сургалтад нэвтрүүлэх санхүү, технологи, арга зөйн шийдлийг оновчтойгоор тодорхойлох, сургалтын процесст оролцогч талуудын сэтгэлгээ, хандлагыг өөрчлөх зэрэг цогцоор нь авч үзвэл зохих боловсрол судлалын тулгамдсан асуудлын нэг болохыг судлаачид анхаарах нь зөйтэй.

Төрийн тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын удирдах алба хаагчдыг бэлтгэх сургалтын арга зөй, технологид ийнхүү өөрчлөлт, шинэчлэлт хийснээр удирдах алба хаагчдыг тасралтгүй бэлтгэх, тэдний мэдлэг ур чадварыг байнга дээшлүүлэх, насан туршдаа суралцах боломж бий болж байгууллагын удирдлагын өйл ажиллагааны чадавхи, хөгжил бодитоор дээшлэнэ гэж дүгнэж байна.